

## ГУРВАН ИХ ГҮРНИЙ ЯЛТЫН БАГА ХУРАЛ БА ДЭЛХИЙН ХОЁРДУГААР ДАЙНЫ ДАРААХ ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

*Г.Төмөрчулуун\**

XX зуунд болсон олон улсын хамгийн чухал дипломат ажиллагааны тухай 10 минутад багтаж ярих нь мэдээж боломжгүй зүйл. Гэхдээ олон улсын харилцаанд бүхэлдээ, энэхүү харилцаанд оролцогч Монгол мэт зарим улсын хувьд эргэлтийн гэхээр түүхэн ач холбогдолтой үйл явдал болсны хувьд түүнийг эргэн дурсаж, тэртээ 60 жилийн өмнө болсон үйл явдалд үнэлэлт дүгнэлт өгөх явдал бол та бидний үүрэг бөгөөд тэрхүү үйл явдлаас бидэнд үлдэх зүйл бол түүний түүхэн сургамж юм шүү гэдгийг юуны өмнө тэмдэглэж хэлмээр байна. Энэ бол Холокаустын гашуун сургамж, нэг үндэстнийг нөгөө үндэстнээс доогуур үзэхийн аюумшигтай хор уршгийн тухай сургамж, бусдын газар нутагт өнгөлзөхийн гашуун сургамж мөн.

Одоогоос 60 жилийн өмнө хуралдсан Ялтын бага хурал XX зууны хоёрдугаар хагасын 3 том асуудлыг шийдвэрлэсэн юм. Үүнд:

- Дэлхийн хоёрдугаар дайныг дуусгавар болгох
- Европ болон Германыг хуваах
- НҮБ-ыг үүсгэн байгуулах

Монголчуудын хувьд энэ гурван гол шийдвэр дээр Монголтой холбогдсон 4 дэх шийдвэрийг нэмэх хэрэгтэй бөгөөд энэ нь Монголын статус-квогийн тухай дайнд ялагч гурван их гүрний удирдагчдын тохиролцоо байлаа. Энэ тухай тусгай илтгэл тавигдах тул дэлгэрүүлэх шаардлагагүй болов уу.

Ялтын тохиролцооны дүнд үйл ажиллагаандаа олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээг удирдлага болгосон НҮБ бий болсон нь улс хоорондын харилцаа шинээр төрж буй олон улсын эрх зүйд тулгуурлан явагдана гэсэн найдлагыг хүн төрөлхтөнд төрүүлж байв. Харамсалтай нь дайнд ялагчдын болон нийт хүн төрөлхтний баяр баясгалан нэн удалгүй “хүйтэн дайн”-аар солигдаж улмаар хүн төрөлхтнийг цөмийн дайны ирмэг дээр аваачиж байсан удаа цөөнгүй гарсан бөгөөд үүний нэг жишээ нь 1961 оны Карибийн хямрал байлаа.

1. XX зууны хоёрдугаар хагасын олон улсын харилцааны үндсэн шинж чанар бол түлшүүртэй байдал үе үе намжиж байсан ч нэлэнхүйдээ “хүйтэн дайн”-ы уур амьсгал зонхилсон үе байлаа. Үүний гол шинж чанар нь олон улсын харилцаа капиталист, коммунист гэсэн хоёр үзэл сурталд хуваагдсан, хоёр туйлт дэлхий ертөнц байсанд оршино. Энэхүү хоёр систем бие биеийн үнэт зүйлс, үзэл суртлын номлолын давуу талыг сурталчлах, илүүлэн үнэмшүүлэхэд улс төр-дипломатын бүхий л арга хэрэгслийг ашиглаж байлаа.

\*Г.Төмөрчулуун - доктор

Энэ нь олон улсын харилцаанд урьд өмнө байгаагүй элдэв онол сургуулиуд үүсэх үндэс болсон юм. “Тогтоон барих”, “түрүүлж цохилт өгөх”, “цөмийн хүлээмж”, “олдын дайн”, “Real politic” нэг талаас, нөгөө талаас “дэлхийн хувьсгал”, “пролетарийн интернационализм”-ийн зэрэг үзэл суртлын номлолууд хойно хойноосоо цуван гарч ирэхэд хүргэжээ. Эдгээр сургууль, номлолууд хоёр системийн нөлөөний хүрээг тэлэх гэсэн үндсэн агуулгатай байлаа. Ийнхүү хайрцагласан хоёр системийн хажуугаар цэрэг улс төрийн аль ч системд орохгүй гэсэн хөгжиж байгаа бүлэг улс “”панча шила” буюу эвсэлд үл нэгдэх гэсэн номлолыг мөн гаргаж ирсэн юм. Хятадын удирдлагын “гурван ертөнцийн” тухай номлол ч үүнээс эхээ авсан түүхтэй.

Хоёр систем өөр өөрсдийн аюулгүй байдлыг хангах үүднээс цэрэг улс төрийн хоёр томоохон эвсэл байгуулсан бөгөөд энэ нь Умард Атлантын Гэрээний Байгууллага /НАТО/, Варшавын Гэрээ байлаа. Үнэн чанартаа энэ хоёр эвсэл хоёр системийн хоорондоо эрс тэс ялгаатай үнэт зүйлсийн практик илрэл байсан юм.

Гурван гүрний Ялтын тохиролцооны дүнд үүсэн бий болсон Ялтын дэг журам буюу Дэлхийн хоёр туйлт тогтолцоо 1989 онд Берлиний хана нурж, хоёр Герман улс нэгдэж, ЗХУ задарсанаар төгсгөл болж зах зээлийн эдийн засаг, ардчилал, эрх чөлөө, хүний эрхийг эрхэмлэн дээдлэх үзэл санаанд тулгуурласан нийгэм байгуулах эрмэлзлэл Дорнод Европ, хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан улс орнуудад эрч хүчээ авч, эдгээр оронд чөлөөт ардчилсан сонгууль явагдан ардчилсан засаг төр тогтов. Үүний хамгийн сүүлийн жишээ Украин болов. Дайны дараах Европыг ардчилах, Польшид чөлөөт ардчилсан сонгууль явуулах тухай 60 жилийн өмнөх Ялтын бага хурлын тохиролцоо нийт Европыг хамарч, нэг үндсэн хууль, нэг мөнгөн тэмдэгт бүхий Европын Холбоо хэмээх олон улсын харилцааны хүчирхэг нэг субъектыг бий болгов. Европын шинэ үндсэн хуулийг батлах санал хураалт өчигдөр Испаниар эхэлснийг та бүхэн мэдэж байгаа. Дэлхийн хоёрдугаар дайны хөлд нэрвэгдэн, тоолж баршгүй гай гамшиг амссан хөгшин Европ ийнхүү өдгөө Моцартын гашуудлын “Рекем”-ээр бус харин түүний “Баяр баясгалан”-гийн сүлд дууллаар төсөөлөгдөх боллоо.

2. Гэвч та бидний амьдран аж төрж буй Азийн байдал харамсалтай нь Европынхоос тэс ондоо байгаад сэтгэл зовох шалтгаан болж байгааг үгүйсгэх аргагүй. Дайны хөлд адилхан нэрвэгдсэн Ази тивийн улс орнуудын хооронд өнгөрсөн түүхээс улбаатай үл итгэлцэх байдал арилаагүй, хуваагдмал улс орнууд оршиж, газар нутгийн маргаан арилаагүй байна. Солонгосын хойгийн асуудал бол үүний тодорхой жишээ юм. 60 жилийн өмнөх НҮБ-ын дүрмийн дагуу маргаантай асуудлаа эв зүгээр, хэлэлцээний аргаар шийдвэрлэх нь огт хуучраагүй

төдийгүй даяаршлын өнөөгийн эрин үед улам ч чухал ач холбогдолтой болж байгаа тэмдэглэх хэрэгтэй.

3. Гэхдээ олон улсын харилцаанд олон улсын эрх зүйг дээдлэх байр суурь Ялгал давамгайлж, чухамдаа НҮБ-ыг үүсгэн бий болгох үндэс суурь болсон бөгөөд энэ нь хэрэг дээрээ АНУ-ын ерөнхийлөгч асан Вудро Вильсоны үзэл санааны үргэлжлэл байсан юм.

Энэ жил 60 жилийн ойгоо тэмдэглэх НҮБ түүхэнд үлдэх алтан хуудас олныг үлдээсэн боловч мөн тэрнээс дутахааргүй гашуун сургамжийг ч үе үе амсаж ирсэн.

Ийм нэг сургамж бол Иракийн хямрал байлаа.

Өдгөө Ялтын бага хурлын шийдвэрээр үүсэн бий болсон НҮБ, түүний Ерөнхий Ассамблейг шинэчлэх асуудал ид яригдаж байна. Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад гол үүрэг бүхий Аюулгүйн Зөвлөлийг шударга үндсэн дээр өргөтгөх, түүний байнгын болон байнгын бус гишүүдийн тоог хөгжиж буй болон хөгжингүй орнуудын зохистой төлөөллийг хангах замаар нэмэгдүүлэх нь чухал гэсэн байр суурь хөгжиж байгаа орнуудын дунд зонхилж байна.

4. Ялтаас хойш олон улсын харилцаа ихээхэн өөрчлөгджээ.

2001 оны 9 дүгээр сарын 11-ний та бидний сайн мэдэх террорист халдлагаас хойш дэлхийд АНУ-ын сүр хүч, санаачлага давамгайлж байна. Олон улсын терроризмтэй тэмцэх олон улсын эвсэл бий болов. Ерөнхийлөгч Бушийн 2 дахь мандат олон улсын алив асуудлыг дипломатын аргаар шийдвэрлэх зүг лүү анхаарах болж байгаа нь НҮБ-ын үүрэг роль, өдгөө түүний Европт хийж буй айлчлал нь Европын холбоотнуудын үүрэг ролийг урьд өмнөхөөс илүү анхаарах найдлагыг төрүүлж байна.

60-аад жилийн тэртээ дайны хөлд нэрвэгдсэн Европ тивд үүсэн бий болсон Европын Холбооны зэрэгцээ Ази тивийн БНХАУ, Энэтхэг улсын эдийн засгийн үсрэнгүй хөгжлөөс үзвэл ойрын 30-40 жил их гүрнүүд болох магадлал ихэссээр байна. Ардчиллын замаар, зах зээлийн эдийн засаг луу шилжиж яваа хүчирхэг Орос улс ч мөн адил.

XXI зуун Азийнх гэж байгаа бол энэ нь гагцхүү энх тайвны нөхцөлд биеллээ олно гэдгийг хэлэх хэрэгтэй юм.

Гэвч орчин үеийн олон улсын харилцаа шулуун дардан замаар явна гэх баталгаа байхгүй. Өмнө нь нэг буюу хэсэг бүлэг улс хүн төрөлхтөнд аюул занал учруулж байсан бол шинжлэх ухаан техник хөгжсөн өнөө үед нэг хүн, хэсэг бүлэг хүн ийм аюул занал учруулж болдгийг 9 дүгээр сарын 11-ний хэрэг явдал харуулсан билээ.

Иймд дэлхийн хоёрдугаар дайн, түүнийг дуусгавар болгосон Ялтын сургамж мартагдах ёсгүй бөгөөд алив шинэ аюул заналыг сөрөн зогсож, хүчээ нэгтгэх шаардлага одоо ч байгааг бид мартах ёсгүй.